



Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД Г
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2019.04.22 № 01/3807.
танай _____ -ны № _____ -т

Г Зөвлөмж хүргүүлэх
тухай Г

Авлигатай тэмцэх газраас Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал болон Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцаад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д заасан чиг үүргийн дагуу дараах "ЗӨВЛӨМЖ"-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журмыг нэг мөр болгож мөрдүүлэх;

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-аас улсын дугаар олгоходоо Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 192 дугаар тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох" журмуудыг баримтлан ажиллаж байгаа нь иргэдийг төөрөгдөлд оруулахын зэрэгцээ тус газрын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны эрх зүйн үндэслэлийг эргэлзээтэй нөхцөл байдалтай болгож байна.

Иймд үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл болон иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй үйлчлэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан нэмэлт өөрчлөлтийг журамд оруулж, нэг мөр ойлгомжтой болгон мөрдүүлэх.

2. Автотээврийн хэрэгслийг бүртгэх, улсын дугаар олгох үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй болгож, хүнд суртал чирэгдлийг арилгах;

Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг, иргэний хяналтын зөвлөлийн гишүүдээс бүрдсэн баг 2019 оны 04-дүгээр сард Автотээврийн үндэсний төвийн Цирк, Да хүрээ, 22-ын товчоо, Баянзүрх дэх салбараар сүүлийн 6 сарын хугацаанд үйлчлүүлсэн 300 гаруй иргэнийг хамруулан санал асуулгын хуудсаар судалгаа явуулсан.

Судалгааны дүнгээс үзэхэд иргэд "АЗ"-ын болон өөрт таалагдсан улсын дугаартай байх гэсэн сэтгэхүй, хүсэл эрмэлзэл ихтэй бөгөөд түүнд тулгуурлан Автотээврийн үндэсний төвийн бүртгэлийн мэргэжилтнүүд иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээндээ тодорхой үнэ, ханш тогтоож, төрийн үйлчилгээг бизнесийн шинж чанартай болгож байна.

Иймд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.2.1 дэх "Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх" заалтын дагуу тээврийн хэрэгслийн улсын дугаарыг иргэдэд нээлттэй, ил тод болгож, үйлчилгээг цахим, шуурхай болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч мэдээллийг олон нийтэд хүргэх үйл ажиллагааг хэвшүүлэх.

3. Шинэчлэн боловсруулж буй "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын төсөлд иргэдэд үзүүлж буй үйлчилгээ, түүнийг үзүүлэх эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны дэс дарааллыг тодорхой тусгаж, ойлголтын зөрүүг арилгах;

C:\DOCUMENTS\ALBANBICHIGVA4

0005316

Зам, тээврийн сайдын 2012 оны 59 дүгээр тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 192 дугаар тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д тээврийн хэрэгслийн улсын дугаарыг өөр тээврийн хэрэгсэлд шилжүүлэн олгохтой холбоотой харилцааг тодорхой зохицуулж өгөөгүйн улмаас иргэд, аж ахуйн нэгжийн хүсэлтийг үндэслэн улсын дугаарын шилжилт хөдөлгөөнийг хийж байгаа нь нийтийн албан тушаалтнуудад авлига, ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдлийг дагуулж байна.

Тухайлбал, Автотээврийн үндэсний төвийн архиваас 2016-2018 оны 01 дүгээр сар хүртэл хугацаанд автомашины улсын дугаар олгосон, шилжүүлсэн 230 хавтас материалтай танилцсаны 67 хавтаснаас бүртгэл, шилжилт хөдөлгөөний зөрчилтэй 132 улсын дугаарын жагсаалт гаргасан. Үүний 50 тохиолдол буюу 37,8 хувь нь улсын дугаар солих хүсэлт бичигдээгүй, мөн зарим улсын дугаар 2-12 тээврийн хэрэгсэл дамжиж солигдсон байна.

Улсын дугаарын шилжилт, хөдөлгөөний үндэслэл болж буй өргөдөл, хүсэлтэд ихэвчлэн гаригийн өөрчлөлт хийлгэх, зарагдаж буй автомашинаасаа улсын дугаараа авч үлдэх, хүүхэд сургуульд хүргэх, өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийн улсын дугаар хооронд нь солих зэрэг шалтгааныг дурьдсан ба зарим тохиолдолд даргын, мэргэжилтний хүсэлтийг үндэслэсэн байлаа.

Иймд авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж буй Улаанбаатар хот серитэй улсын дугаарыг солих, шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг тодорхой журамласан зохицуулалтыг оруулах шаардлагатай байна.

Төслийн 2.6-д "...тухайн автотээврийн хэрэгсэл нь ашиглалтаас хасагдсанаас хойш өмчлөгчийн хүсэлтээр 3 сар хүртэл хугацаагаар хадгалж болно. Тухайн хугацаа өнгөрсний дараа уг улсын дугаарыг дахин олгоно. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд бүртгэлийн байгууллагын даргын шийдвэрээр авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг солино." гэж заасныг тодорхой болгож тусгах;

Мөнзайлшгүй шаардлагатай, ...даргын шийдвэрээр... гэсэн заалтын үндэслэлийг тодорхой болгох.

4. Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн програм хангамжийг боловсронгуй болгож, түүнд тавих хяналтын нэгжийн үйл ажиллагааг сайжруулах;

Тус газрын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа VRS програмын админ эрхийг Зам, тээврийн хөгжлийн яамны мэргэжилтэн эзэмшиж, уг бүртгэлийн програмд өөрчлөлт оруулах тохиолдолд түүнд ханддаг байна.

Энэхүү зохион байгуулалтын хэлбэр нь оновчтой бус байгаагийн илрэл нь уг админ эрхийг эзэмшиж байсан Зам, тээврийн хөгжлийн яамны мэргэжилтэн бүртгэлийн програмд нэвтрэх эрхээ ашиглан, тээврийн хэрэгслийн улсын дугаарын бүртгэл, шилжилт, хөдөлгөөнтэй холбоотой хууль бус үйлдэл хийж Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэст шалгагдсан.

Иймд Зам, тээврийн хөгжлийн яамны мэргэжилтэн /админ/ эрхийг Автотээврийн үндэсний төвд шилжүүлэх эсвэл ямар эрх хэмжээтэй байх талаар журамд тодорхой зохицуулалт оруулж өгөх.

Бүртгэлийн системийг боловсронгуй болгох асуудлын хүрээнд иргэдэд үзүүлж буй үйлчилгээ нэг бүрийг үзүүлэлт болгон оруулахын зэрэгцээ бүртгэлийн мэргэжилтнүүдийн хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны процесс дэс дараалал, ажлын дүн мэдээ, тэдэнд тавих хяналтын тогтолцоог иж бүрэн тусгахад анхаарах.

Тус төвөөс олгож буй "С" зөвшөөрөлд хяналт тавих ажиллагаанд ашиглаж буй QR кодын системийг тээврийн хэрэгслийн гэрчилгээнд нэвтрүүлж, бүртгэлийн болон тээврийн цагдаагийн програмтай холбох замаар хуурамч тээврийн хэрэгслийн гэрчилгээ ашиглаж түр горимоор орж ирсэн, сэлбэг нэрээр оруулж ирж угсарсан тээврийн хэрэгслийг гэрчилгээжүүлэх, мөн бусдын тээврийн хэрэгслийн гэрчилгээг ашиглаж

шилжүүлэн авч хууль бус хөрөнгийн маргаан гаргадаг гэх мэт асуудлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар судалж шийдвэрлэх нь зүйтэй.

5. Албан хаагчдын үүрэг хариуцлага, ёс зүйн байдлыг сайжруулан, дотоод хяналтыг нэмэгдүүлэн авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, чиг үүргээ хэрэгжүүлэх;

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын харьяа салбаруудын үйл ажиллагаатай танилцах явцдаа иргэдээс авсан санал асуулгын судалгаанд улсын дугаарыг 200,000 төгрөгөөс 10,0 сая хүртэл төгрөгөөр үнэлэгдсэн талаар, мөн бүртгэлийн ажилтан, ахлах ажилтан, орлогч дарга нар улсын дугаарын үйлдвэр, аль нэг даатгалын компанийн ажилтан, ченж болон бусад автомашин борлуулдаг иргэдтэй тохиролцож, үгсэн хуйвалдах замаар улсын дугаар олгох үйл ажиллагааг бизнес буюу тухайн ажлын байр нь мөнгө олох нөхцөл боломжийг бүрдүүлж байгаа талаар дурьдагдсан байна. Авлига гарах шалтгаан, нөхцлийг судалж, арилгах ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна. Тухайлбал:


Шинэчлэн боловсруулж буй журамд байгууллагын удирдлагаас бүртгэгч хүртэл албан тушаалтнуудыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах чиглэлээр үйл ажиллагааг журамласан бүлэг зохицуулалтыг боловсруулан тусгах;

Дотоод хяналтыг сайжруулж, албан хаагчдын шударга байдлын үнэлгээг сайжруулах чиглэлээр удирдлага зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.1.2.5-дахь "төрийн үйлчилгээний шударга, ил тод, нээлттэй байдлын талаархи судалгааг тогтмол хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах" заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, хариуг Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу 2019 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



ХЭНХЖАРГАЛ